

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2010 оны 5 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 149

Улаанбаатар хот

Г “Даатгалын байгууллагад аудит хийх”-ийг
үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг
шинэчлэн батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.3, 6.2.4, Даатгалын тухай хуулийн 33.2.2, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 20.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Даатгалын байгууллагад аудит хийх үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн “Даатгалын байгууллагад аудит хийх, аудитын байгууллагад эрх олгох, томилох, аудиторос шалгалт авах журам” батлах тухай 174 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Батлагдсан журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн тайлагнал, аудит, үнэлгээний чанарын хяналтын газар /М.Болортуяа/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-г тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГАД АУДИТ ХИЙХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ноос даатгалын байгууллагад аудит хийх аудитын байгууллагад эрх олгох, ~~еунгаж~~, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, аудитын байгууллагыг томилох, даатгалын байгууллагад аудит хийхэд тавигдах нэмэлт шаардлага, тэдний үйл ажиллагаанд хяналт тавих, аудиторыг сургалтад хамруулж, шалгалт авахтай холбогдсон харилцааг зохицуулна.

/Энэ хэсэгт Хорооны 2014 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан/

Хоёр. Аудитын байгууллагад эрх олгох ~~еунгаж~~, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох

/Энэ хэсэгт Хорооны 2014 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан/

2.1. Хороо Аудитын тухай хуульд зааснаас гадна дараах шаардлагыг хангасан аудитын байгууллагад эрх олгоно:

2.1.1. санхүү, төвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон аудит хийх тусгай зөвшөөрөл нь хүчинтэй байх;

2.1.2. даатгалын байгууллагад аудит хийх үйл ажиллагааны төрөлжсөн сургалтад хамрагдаж, үнэмлэх авсан хоёроос доошгүй аудитортой байх;

/Энэ хэсэгт Хорооны 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 400 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

2.1.3. Хорооноос шаардлагатай гэж үзсэн бусад шаардлагыг хангасан байх.

2.2. Дээрх шаардлагыг хангасан аудитын байгууллага дор дурьдсан баримт бичгийг Хороонд ирүүлнэ:

2.2.1. эрх олгохыг хүссэн өргөдлийг энэ журмын нэгдүгээр хавсралтын дагуу;

2.2.2. аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн болон аудитын байгууллагын тусгай зөвшөөрлийн гэрчилгээг нотариатаар баталгаажуулсан хуулбарын хамт;

2.2.3. аудитын байгууллага, түүний удирдлагын талаарх тодорхойлолтыг энэ журмын хоёрдугаар хавсралтаар, аудитын байгууллагын аудиторуудын тодорхойлолтыг энэ журмын 3 дугаар хавсралтаар тус тус;

2.2.4. компанийн танилцуулга болон дүрэм;

2.2.5. даатгалын байгууллагад аудит хийх дотоод стандарт;

2.2.6. Хорооноос олгосон аудиторуудын үнэмлэхний хуулбар;

/Энэ хэсэгт Хорооны 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 400 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

2.2.7. даатгалын байгууллагад аудит хийх эрх бүхий аудиторууд нь ёс зүйн зөрчил гаргаж байгаагүй, эсхүл зөрчилгүйд тооцогдох хугацаа нь дууссан эсэх талаар Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтээс гаргасан тодорхойлолт.

2.3. Хороо аудитын байгууллагаас ирүүлсэн баримт бичгийг хүлээн авч шалгаснаас хойш ажлын 30 хоногийн дотор хянаж шийдвэрлэнэ.

2.4. Хороо аудитын байгууллагыг шаардлага хангасан гэж үзвэл даатгалын байгууллагад аудит хийх **эрхийн гэрчилгээ** эрхийг ~~3~~ жилийн хугацаагаар олгоно. Даатгалын байгууллагад аудит хийх эрх авсан аудитын байгууллагад олгох Гэрчилгээний загварыг энэхүү журмын дөрөвдүгээр хавсралтын дагуу хэвлэнэ.

/Энэ хэсэгт Хорооны 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 400 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

/Энэ хэсэгт Хорооны 2014 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан/

2.5. Аудитын байгууллага даатгалын байгууллагад аудит хийх эрхийн хугацаа дуусахаас 1 сарын өмнө эрх сунгуулах хүсэлтээ Хорооны Ажлын албанд бичгээр ирүүлнэ.

/Энэ хэсэгт Хорооны 2014 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан/

2.6. Даатгалын байгууллагад аудит хийх эрхийг сунгах хүсэлтийг Ажлын алба тухайн байгууллагын ажлын гүйцэтгэлийн дүн, чанар байдлыг харгалзан сунгах эсэх асуудлаар холбогдох санал боловруулж Хороогоор шийдвэрлүүлнэ.

/Энэ хэсэгт Хорооны 2014 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан/

2.7. Хороо эрх олгох, эрхийг сунгахаас **эрх олгохоос** татгалзсан тохиолдолд энэ тухай үндэслэл бүхий мэдэгдлийг хүсэлт гаргасан аудитын байгууллагад албан ёсоор хүргүүлнэ.

/Энэ хэсэгт Хорооны 2014 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан/

2.8. Эрх авсан аудитын байгууллага дараах зөрчил дутагдал гаргасан тохиолдолд ~~6~~ сар хүртэл **нэг жилийн** хугацаагаар эрхийг түдгэлзүүлнэ.

/Энэ хэсэгт Хорооны 2014 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан/

2.8.1. даатгалын байгууллагын санхүүгийн тайланг санаатай болон болгоомжгүйгээр буруу баталгаажуулсан, аудитын үйл ажиллагааны зарчмыг зөрчсөн, үйлчлүүлэгчийн болон нийтийн ашиг сонирхолд хохирол учруулсан, түүнтэй адилтгах нөхцөл байдал үүсгэсэн;

2.8.2. Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй;

2.8.3. даатгалын зах зээлийн нэр хүнд, тогтвортой байдалд хохирол учруулахуйц ёс зүйн болон үйл ажиллагааны ноцтой алдаа гаргасан;

2.8.4 Хороо ашиг сонирхолын зөрчил бүхий нөхцөл байдал бий болсон гэж үзсэн;

2.8.5 энэ журмын 5.2, 5.3-т заасныг хангаагүй;

2.8.6. холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн нь тогтоогдсон.

2.9. Хороо аудитын байгууллага гаргасан зөрчлөө түдгэлзүүлсэн хугацаанд бүрэн арилгасан нөхцөлд даатгалын байгууллагад аудит хийх эрхийг сэргээнэ.

2.10. Хороо дор дурьдсан үндэслэлээр аудитын байгууллагын даатгалын байгууллагад аудит хийх эрхийг хүчингүй болгоно:

2.10.1. аудитын байгууллага өөрөө хүсэлт гаргасан;

2.10.2. эрхийг түдгэлзүүлсэн хугацаанд Хорооноос тавьсан шаардлага, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй;

2.10.3. даатгалын байгууллагад аудит хийх эрхийг хуурамч баримт бичиг бүрдүүлэн авсан нь тогтоогдсон;

2.10.4. холбогдох хууль тогтоомж болон энэ журмыг удаа дараа болон ноцтой зөрчсөн;

2.10.5. даатгалын байгууллагын нууцтай холбогдсон мэдээллийг бусдад задруулсан, дамжуулсан нь тогтоогдсон;

2.10.6. алдаатай болон хуурамч дүгнэлт гаргасан;

2.10.7. Хорооноос даатгалын байгууллагад аудит хийх үнэмлэх авсан аудиторын тоо энэ журамд заасан хэмжээнд хүрэхээ больсон;

/Энэ хэсэгт Хорооны 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 400 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

2.10.8. санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулага аудитын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.

2.11. Хорооны тусгай зөвшөөрөл, эрхийн нэгдсэн бүртгэл хариуцсан ажилтан даатгалын байгууллагад аудит хийх эрх олгосон болон эрхийг нь түдгэлзүүлсэн, сэргээсэн хүчингүй болгосон талаарх дэлгэрэнгүй бүртгэлийг хөтөлж Даатгалын газарт тухай бүр мэдэгдэж байна.

2.12. Даатгалын байгууллагад аудит хийх эрхийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон тухай Хорооны шийдвэрийг Даатгалын газар ажлын 10 хоногт багтаан даатгалын байгууллагуудад албан бичгээр, олон нийтэд цахим сүлжээгээр мэдээнэ.

2.13. Журмын 2.10.2-2.10.6-д заасан үндэслэлээр эрх нь хүчингүй болсон аудитын компани 3 жилийн хугацаанд Хороонд дахин хандах эрхгүй.

/Энэ заалтыг Хорооны 2014 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор нэмсэн/

Гурав. Даатгалын байгууллагад аудит хийх үйл ажиллагааны төрөлжсөн сургалтыг зохион байгуулах, шалгалт авах

3.1 Аудиторт даатгалын байгууллагад аудит хийх үйл ажиллагааны төрөлжсөн сургалтыг Хороо, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институттэй хамтарсан Комисс /цаашид “Комисс” гэх/ хариуцан гүйцэтгэнэ.

3.2. Комисс нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдсэн орон тооны бус 5-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд тэднийг Ажлын албаны саналыг үндэслэн Хорооны дарга томилж чөлөөлнө.

3.3. Комиссын дарга нь Хорооны аудитын чанарын хяналт хариуцсан нэгжийн дарга байна.

3.4. Комиссын гишүүд дараах эрх үүрэгтэй:

3.4.1. сургалт зохион байгуулах тухай бүрд сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж Хорооны даргаар батлуулна.

3.4.2. сургалтын талаарх мэдээллийг сургалт эхлэхээс 10-аас доошгүй хоногийн өмнө хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудас, бусад хэлбэрээр олон нийтэд хүргэнэ.

3.4.3. сургалтыг техник, тоног төхөөрөмжийн шаардлага хангасан орчин бүрдсэн газарт гарын авлага, тараах материал нь сургалтад оролцогч бүрт хүртээмжтэй байхаар зохион байгуулна.

- 3.4.4. шалгалтын асуулт, тестийг бусдаар бөглүүлэх, хуулах зэрэг шудрага бус үйлдэл хийсэн шалгуулагчийг протоколд тэмдэглэж, шалгалтаас хасах;
- 3.4.5. шалгалтын тест болон асуултын нууцыг чанд хадгалах;
- 3.4.6. шалгалтын комиссын үйл ажиллагаанд өөрийн биеэр оролцох;
- 3.4.7. шалгалтын дүнг Хороонд танилцуулах.

3.5. Комиссын нарийн бичгийн дарга дараах эрх, үүрэгтэй:

- 3.5.1 сургалтад хамрагдахаар өргөдөл гаргасан аудиторуудын баримт бичгийг энэхүү журамд нийцүүлэн хүлээн авч бүртгэх;
- 3.5.2. шалгалтын болон Комиссын хурлын тэмдэглэл хөтөлж, баримт бичгийг цэгцлэн Хорооны архивт шилжүүлэх.

3.6. Сургалт шалгалтын төлбөрийн хэмжээг Хороо тогтоох бөгөөд шаардлагатай гэж үзвэл шинэчлэн тогтоож болно.

3.7. Даатгалын байгууллагад аудит хийх үйл ажиллагааны төрөлжсөн сурталтад хамрагдахыг хүссэн аудитор дараах баримт бичгийг Хороонд ирүүлнэ:

- 3.7.1. сургалтад хамрагдахыг хүссэн өргөдөл;
- 3.7.2. иргэний үнэмлэхний хуулбар;
- 3.7.3 цээж зураг /3x4 хэмжээтэй/;
- 3.7.4. мэргэшсэн нягтлан бодогчийн гэрчилгээ, аудит болон баталгаажуулах үйлчилгээ эрхлэх эрхийн батламжийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;
- 3.7.5 сургалтын төлбөр төлсөн баримт.

3.8. Эрх олгох шалгалтыг Комисс зохион байгуулах бөгөөд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

3.8.1. шалгалт нь хоёр шаттай байх бөгөөд нэг дэх шатны шалгалтыг тестээр, хоёр дахь шатны шалгалтыг ярилцлага хэлбэрээр авна;

3.8.2. сургалтын багц цагийн 80 болон түүнээс дээш хувьд хамрагдсан аудиторыг шалгалтад оруулна;

3.8.3. тестийн хувилбар боловсруулах, нэгтгэх ажлыг Комиссын шийдвэрээр томилогдсон гишүүн гүйцэтгэх бөгөөд тестийн эцсийн хувилбарыг Комиссын хурлаар батлан битүүмжилнэ;

3.8.4. тестийг битүүмжилсэн байдлаар шалгалт авах танхимд хүргэх бөгөөд шалгалтад оролцогчдыг байлцуулан битүүмжийг задлана;

3.8.5. тестийн асуултын 60 буюу түүнээс дээш хувийг үнэн зөв бөглөсөн аудиторыг хоёр дахь шатны шалгалтад оруулна;

3.8.6. ярилцлагад тавигдах асуултын агуулга, хүрээг Комисс батална.

3.8.7. хоёр дахь шатны шалгалтад тэнцсэн аудиторт Комиссын шийдвэрийг үндэслэн 3 жилийн хугацаатай үнэмлэх олгоно. Аудиторуудад олгох үнэмлэхний загварыг энэхүү журмын тавдугаар хавсралтын дагуу хэвлэнэ.

/Энэ хэсэгт Хорооны 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 400 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

3.8.8. Хороо сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэн аудиторт үнэмлэхийг 3 жилийн хугацаагаар олгох бөгөөд хугацаа дууссан тохиолдолд дахин сургалтад хамрагдаж шалгалт өгнө.

/Энэ хэсэгт Хорооны 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 400 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

Дөрөв. Аудитын байгууллагыг томилох

4.1. Даатгалын байгууллага нь Даатгалын тухай хуулийн 33.2, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 20.2-д заасны дагуу аудитын байгууллагыг томилно.

4.2. Даатгалын байгууллага даатгалын байгууллагад аудит хийх эрхгүй аудитын байгууллагаар аудит хийлгэсэн тохиолдолд Хороо даатгалын байгууллагын оролцоогүйгээр эрх бүхий аудитын байгууллагыг сонгон томилж санхүүгийн тайланд дахин аудит хийлгэнэ.

4.3. Хороо аудитын байгууллагыг энэхүү журмын 4.2-т заасны дагуу томилохдоо тухайн тайлангийн жилд хамгийн олон даатгалын байгууллагад аудит хийсэн аудитын байгууллагыг эхний ээлжинд сонгох зарчмыг баримтлана.

4.4. Тухайн сонгогдсон аудитын байгууллага уг ажлыг гүйцэтгэх боломжгүй тухайгаа мэдэгдсэн тохиолдолд Хороо дараагийн эрх бүхий аудитын байгууллагыг сонгоно.

4.5. Хорооноос даатгалын байгууллагад аудит хийх эрх аваагүй аудитын байгууллагаас аливаа даатгалын байгууллагын үйл ажиллагааны талаар гаргасан тайлан, дүгнэлт нь хүчин төгөлдөр бус байна.

4.6. Энэ журмын 4.2-т заасны дагуу Хорооноос сонгож томилсон аудитын байгууллагын ажил, үйчилгээтэй холбогдох бүхий л зардлыг тухайн даатгалын байгууллага бүрэн хариуцна.

Тав. Даатгалын байгууллагад аудит хийхэд тавигдах нэмэлт шаардлага

5.1. аудитор бие даан даатгалын байгууллагад аудитын үйл ажиллагаа явуулахгүй бөгөөд даатгалын байгууллагад аудит хийсэн аудитын тайлан, дүгнэлтийн хариуцлагыг аудитын компани хүлээнэ.

5.2. аудитын байгууллага нь даатгалын байгууллагад аудит хийхдээ дараах нөхцлүүдийг бий болгосон байна.

5.2.1. даатгалын аудитын ажлын багт үнэмлэхтэй аудиторууд ажилласан байх;
/Энэ хэсэгт Хорооны 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 400 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

5.2.2. даатгалын байгууллагад аудит хийхэд аливаа ашиг сонирхолын зөрчилгүй байх.

5.3. Аудитор нь Аудитын тухай хуулийн 4, Даатгалын тухай хуулийн 36, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 22 дугаар зүйлд зааснаас гадна даатгалын байгууллагын санхүүгийн тайлангийн дор дурьдсан зүйлсийг шалган дүгнэлт өгсөн байна.

5.3.1. даатгалын байгууллагын санхүүгийн тайлангийн нэмэлт мэдээлэлийн үнэн зөвийг холбогдох орлого, зарлага, мөнгөн гүйлгээ, бусад шаардлагатай санхүүгийн баримт, бичгийг үндэслэн шалгаж баталгаажуулах;

5.3.2. даатгалын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, заавар, журмын дагуу нягтлан бодох бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэн хөтлөх, олон улсын стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхэд нь даатгагчид туслалцаа үзүүлэх, зөвлөгөө өгөх, стандартын хэрэгжилтийг шалгах;

5.3.3. давхар даатгалын үйл ажиллагаа нь Хорооноос баталсан холбогдох шаардлагын дагуу явагдаж буй эсэх, даатгагчийн давхар даатгалын гэрээ, тайлан, давхар даатгалын нөхөн олговрын төлөгдсөн байдал, хураамж, давхар даатгагч компанийн санхүүгийн болон төлбөрийн чадварын байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх;

5.3.4. мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж буй эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх;

5.3.5. даатгалын нөхөн олговор олголт болон баримт бүрдүүлэлтийн байдалд үнэлгээ өгөх;

5.3.6. даатгагчийн төлбөрийн чадвар, хөрөнгө оруулалт, санхүүгийн чадавхид үнэлэлт дүгнэлт өгөх;

5.3.7. даатгагчийн эд хөрөнгийн чанар, хөрөнгө оруулалт, хөрөнгө санхүүгийн эх үүсвэр, компанийн хувьцаа, ногдол ашиг хуваарилалт, зээл олголтын байдлыг хянаж, үнэлэлт дүгнэлт өгөх;

5.3.8. даатгалын нөөц сангийн бүрдүүлэлт, хуваарилалт нь зохих журмын дагуу явагдаж байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх;

5.3.9. даатгалын нөөц сангуудын байршлыг шалгаж баталгаажуулах;

5.3.10. даатгагчийн гэрээгээр хүлээсэн эрх үүрэг, хариуцлага болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааг тогтоож, дүгнэлт гаргах.

5.4. Аудитор нь Даатгалын байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Даатгалын тухай хуулийн 36, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан нөхцөл байдал бий болсон тухай болон хязгаарлалттай дүгнэлт өгсөн эсхүл дүгнэлт өгөхөөс татгалзсан тохиолдолд Хороонд нэн даруй мэдэгдэнэ.

Зургаа. Хяналт, хариуцлага

6.1. Хороо энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах бөгөөд зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--ooOoo---

Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 149 тоот тогтоолоор батлагдсан “Даатгалын байгууллагад аудит хийх үйл ажиллагааг зохицуулах журам” журмын нэгдүгээр хавсралт

ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГАД АУДИТ ХИЙХ АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ЭРХ ХҮССЭН ӨРГӨДӨЛ

Огноо:

Хаана: Санхүүгийн зохицуулах хороо,
Засгийн газрын IV байр
Бага тойруу-6,
Улаанбаатар-46,
Монгол Улс

Хэнээс:

(*өргөдөл гаргагч хуулийн этгээдийн хаяг, байршил, утас, факс, электрон шуудангийн хаягийг бүрэн дэс дарааллаар нь бичнэ үү.*)

.....
/хуулийн этгээдийн нэр/

Аудитын байгууллагын үндсэн үйл ажиллагаа болон нэмэлт үйл ажиллагааны талаар бичих:

- 1/.....
- 2/.....
- 3/.....
- 4/.....
- 5/.....

/байгууллагын үйл ажиллагааны төрөл/

Аудитын байгууллагын үүсгэн байгуулагч иргэд, хуулийн этгээд нь дараах мэдээллийг үнэн зөв бичнэ үү. Үүнд:

№	Овог, нэр <i>/Хуулийн этгээдийн нэр/</i>	Регистрийн дугаар	Иргэний үнэмлэхийн дугаар <i>/Хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар/</i>	Хаяг	Хувь нийлүүлэх хөрөнгийн хэмжээ (мянган төгрөгөөр)

Аудитын байгууллагын үүсгэн байгуулагч /үүсгэн байгуулагчид/ нь өөрийн хууль ёсны өмчлөлд байгаа мөнгөн хөрөнгөөр хувь нийлүүлсэн болно.

Аудитын байгууллагын захирал, аудиторууд нь Аудитын тухай хуулийн 17, 25.2-т тус тус заасан шаардлагыг хангасан дараах хүмүүс ажиллаж байгаа болно. Үүнд:

№	Овог, нэр	Одоогийн эрхэлж байгаа ажил	Регистрийн дугаар	Иргэний үнэмлэхийн дугаар	Аудитын байгууллагад эрхлэх албан тушаал

Даатгалын байгууллагад аудит хийх эрх хүссэн Хороонд бүрдүүлж хүргүүлсэн баримт бичгүүдийг Компанийн тухай хууль, Аудитын тухай хууль, Даатгалын тухай хуульд нийцүүлэн гаргасан Санхүүгийн зохицуулах хорооны ... оны ... дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар тогтоолоор батлагдсан “Даатгалын байгууллага аудит хийх үйл ажиллагааг зохицуулах журам”-ын шаардлагад нийцүүлэн үнэн зөв бүрдүүлсэн болно. Бүрдүүлсэн баримт бичигт ямарваа худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

Өргөдөл, баримт бичгүүдийг хүлээн авч, хянан шийдвэрлэж даатгалын байгууллагад аудит хийх эрх олгоно уу.

Даатгалын байгууллагад аудит хийх эрх авсан тохиолдолд Аудитын тухай хууль, Даатгалын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж ажиллах болно.

ӨРГӨДӨЛ ГАРГАГЧ:

/тамга/

*/...../
/хуулийн этгээдийн нэр/*

*/...../
/албан тушаал/*

*/...../
/гарын үсэг/*

*/...../
/овог, нэр/*

Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 149 тоот тогтоолоор батлагдсан “Даатгалын байгууллагад аудит хийх үйл ажиллагааг зохицуулах журам” журмын хоёрдугаар хавсралт

АУДИТЫН БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТОДОРХОЙЛОЛТ

А. Аудитын байгууллагад ямар албан тушаал эрхэлдэг талаар тэмдэглэнэ:

- Байгууллагын дарга
- Орлогч дарга
- Бусад
/Албан тушаалыг тодорхой бичих/

Б. Аудитын байгууллага, түүний удирдлага нь дараах мэдээллийг үнэн зөв бичиж ирүүлнэ үү. Үүнд:

1. Аудитын байгууллага:


- Оноосон нэр:
- Байгуулагдсан он, сар, өдөр:
- Үйл ажиллагаа эрхлэх хугацаа:
- Байршил буюу хаяг:
- Улсын бүртгэлийн дугаар:
- Регистрийн дугаар:
- Аудитын байгууллагын удирдлагын овог, нэр:
- Аудитын байгууллагын үйл ажиллагаатай холбогдсон танилцуулга:

.....
.....
.....
.....

/эрхэлж ирсэн үйл ажиллагаа тус бүрийг эрхэлсэн хугацаагаар нь, хараат буюу охин компанитай эсхүл нэгжтэй эсэх, тэдгээрийн болон тухайн байгууллагын үйл ажиллагаа, санхүүгийн үр дүн, байршил, өмчлөлийн байдал, бусад байгууллагад хувь нийлүүлсэн хөрөнгө зэргийг хамруулан бичнэ/.

2. Удирдлага:

- Овог, нэр:
- Эрхлэж буй албан тушаал:
- Иргэний харъяалал:
- Иргэний үнэмлэхний дугаар:
- Регистрийн дугаар:
- Нийгмийн гарал:
- Гэр бүлийн байдал:
- Гэрийн хаяг:
- Утасны дугаар:



- Боловсролын талаар */Ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ/*

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он	Диплом, гэрчилгээний дугаар

- Ажлын туршлагын талаар:

№	Хаана ажиллаж байсан	Албан тушаал	Ажилд орсон он, сар, өдөр	Ажлаас гарсан он, сар, өдөр	Шалтгаан

“_____ - Аудит” ХХК нь аудитын байгууллагын хуулиар зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа явуулах бөгөөд холбогдох материалуудыг үнэн зөв, хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэн танайд хүргүүлсэн болохоо нотлохын зэрэгцээ үүнээс үүсэх аливаа эрсдлийг хууль тогтоомжийн дагуу бүрэн хариуцахаа илэрхийлж байна.

/...../ /...../
/хуулийн этгээдийн нэр/ /албан тушаал/

/...../ /...../
/гарын үсэг/ /овог, нэр/

Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 149 тоот тогтоолоор батлагдсан “Даатгалын байгууллагад аудит хийх үйл ажиллагааг зохицуулах журам” журмын гуравдугаар хавсралт

АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН АУДИТОРЫН ТОДОРХОЙЛОЛТ


А. Аудитын байгууллагад ямар албан тушаал эрхэлдэг талаар тэмдэглэнэ:

- Үндсэн аудитор
- Бусад
/Тодорхой бичих/

Б. Аудитын байгууллагын аудитор нь дараах мэдээллийг үнэн зөв бичиж ирүүлнэ үү. Үүнд:

1. Аудитор:

- Овог, нэр:
- Иргэний харьяалал:
- Иргэний үнэмлэхний дугаар:
- Регистрийн дугаар:
- Нийгмийн гарал:
- Гэр бүлийн байдал:
- Гэрийн хаяг:
- Утасны дугаар:
- Төрөл төрөгсөд болон ам бүлийн тоо:



Товч намтар түүх:

.....
.....
.....
.....
.....
.....

(Урьд өмнө эрхэлж байсан ажил, төрлийн байдал, аль нэг хуулийн этгээдийг төлөөлдөг эсэх, түүний үйл ажиллагаа, байршил, даатгалын байгууллагатай харьцаж байсан түүх, даатгалын байгууллагын хувь нийлүүлэгч эсэх, Аудитын болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчиж хариуцлага хүлээж байсан эсэх,

одоо хууль хяналтын байгууллагад хэрэг үүсгэгдсэн эсэх зэрэг тухайн үйл ажиллагааг эрхэлхэд аливаа сонирхлын зөрчил бүхий нөхцөл байдал байгаа эсэхийг тодорхой гаргацтай, үнэн зөв бичнэ):

- Боловсролын талаар (Ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ):

№	Хаана ямар сургууль	Элссэн он сар	Төгссөн он сар	Эзэмшсэн мэргэжил	Диплом № Гэрчилгээ №

- Ажил, мэргэшлийн туршлагын талаар:

№	Хаана ажиллаж байсан (албан газар тухайн үеийн нэрээр бичнэ)	Албан тушаалд ажилласан	Ажилд орсон он, сар, өдөр	Ажлаас гарсан он, сар, өдөр	Шалтгаан

ӨРГӨДӨЛ ГАРГАГЧ

/...../
(гарын үсэг)

/...../
(овог, нэр)

Он, сар, өдөр

Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны
149 тоот тогтоолоор батлагдсан “Даатгалын
байгууллагад аудит хийх үйл ажиллагааг
зохицуулах журам”-ын дөрөвдүгээр хавсралт



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГАД АУДИТ
ХИЙХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар . . .

. . . оны . . . сарын . . . өдөр

Улаанбаатар хот

Монгол улсын Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, болон бусад хууль тогтоомж, Хорооны 2010 оны 149 дүгээр тогтоолоор батлагдсан “Даатгалын байгууллагад аудит хийх үйл ажиллагааг зохицуулах журам”-д заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны ____ оны ____ сарын ____ өдрийн ____ дугаар тогтоолыг үндэслэн _____ хот, аймаг дахь, _____ регистрийн дугаартай, _____ улсын бүртгэлийн гэрчилгээний дугаартай _____-д энэхүү эрхийн гэрчилгээг олгов.

ДАРГА

Тамга

(Гарын үсэг)

(Нэр)

(Энэхүү гэрчилгээ нь хавсралтын хамт хүчинтэй болно.)



**МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО**

_____ **ТООТ**

**ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ
ХАВСРАЛТ**

/Даатгалын байгууллагад аудит хийх аудитын
байгууллагын тэмдэглэлүүд/

Тэмдэг

(Энэхүү хавсралт нь эрхийн гэрчилгээний хамт хүчинтэй болно.)

ТАВ. Бусад өөрчлөлтийн тэмдэглэл:


№	Өөрчлөлтийн тэмдэглэл	Өөрчлөлтийг бүртгэсэн огноо, тэмдэг, гарын үсэг

Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 149 тоот тогтоолоор батлагдсан “Даатгалын байгууллагад аудит хийх үйл ажиллагааг зохицуулах журам”-ын тавдугаар хавсралт



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Дугаар...



/Тэмдэг/

сунгав.
_____ ХХК-ийн аудитор
_____ овогтой
_____ -д
(Нэр)

Даатгалын байгууллагад аудит хийх төрөлжсөн сургалтад сууж, шалгалтад тэнцсэн тул Санхүүгийн зохицуулах хорооны даргын 20__ оны ____ - р тушаалаар энэхүү үнэмлэхийг олгов.

20__ оны ____ сарын ____ өдрийг хүртэл

Санхүүгийн зохицуулах хорооны дарга

(Гарын үсэг)
(Нэр)

Тамга

20__ оны ____ сарын ____ өдрийг хүртэл

Санхүүгийн зохицуулах хорооны дарга

(Гарын үсэг)

Тамга